



**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2024.12.26

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлж, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 9 зорилтын хүрээнд 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **95.71** хувьтай, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 21 арга хэмжээнээс 100 хувьтай 14 арга хэмжээ, 90 хувьтай 6 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.				
Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:				
1	Арга хэмжээ 2.5.2 Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчилнэ.	-Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Хот байгуулалтын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХББОСС-ын 2024 оны 79 дүгээр тушаалаар байгуулж, шинээр батлагдсан хууль тогтоомжтой уялдуулан боловсруулах, "20 минутын хот" стандартыг нэвтрүүлэх, холбогдох хуулийн уялдааг сайжруулах чиглэлээр “Хууль зүйн бичигт хүрээлэн” НҮҮТББ-тай 2024.12.02-ны өдрийн 2024/192 тоот зөвлөх үйлчилгээний гэрээг гэрээ	90

		<p>ажлын хэсэгт ажилласан байна. -Хот, суурин газрын ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна. -"Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийг шинэчлэн боловсруулна. -"Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх" /БНБД 31-01-10/ барилгын норм ба дүрмийг шинэчлэн боловсруулсан байна. -"Олон нийт иргэний барилга" /БНБД 31-03-03/ барилгын норм ба дүрмийг батлуулсан байна.</p>	<p>байгуулан ажиллаж байна. -БХБ-ын сайд, БОАЖ-ын сайд нарын хамтарсан 2023 оны 35/ А/36 тоот тушаалаар байгуулсан Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийн 2024 оны төлөвлөгөө"-г батлуулан, хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөл, олон улсын ижил төстэй хуулийн судалгааг боловсруулсан. - "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт" /БНБД 30-01-.../-ийн Норм ба дүрмийн төслийг ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр ирүүлснийг техникийн даалгаврын дагуу дахин боловсруулах шаардлагатай тул 2024 оны 03/807 тоот албан бичгээр буцаасан. /70 хувь/ "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт" /БНБД 31-01-24/, Олон нийт иргэний барилга" /БНБД 31-01-03*/11/-ыг хянан үзээд хооронд нь нийцүүлэн дахин хянан тохиолдуулах шаардлагатай байх тул 2024.08.29-ны өдрийн 03/365 дугаар албан бичгээр буцаан төслүүдийн боловсруулалтыг сайжруулж, хянан тохиолдуулж, хамтад нь тус хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p>	
2	<p>Арга хэмжээ 2.5.3 Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.</p>	<p>Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө концепцийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.</p>	<p>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төсөлд БНСУ-ын "Дэхан консалтентс" ХХК-тай 2024 оны НХААГ/20240103 147 тоот гэрээ байгуулж, дүгнэлт зөвлөмж гаргуулсан. Төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийг боловсруулах 2024/03, 2024/01, 2024/06 дугаартай ажлын даалгаврыг боловсруулж, ХББОС-ын сайд Ж.Батсуурь, МУ-ын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нараар 2024.11.01-ний өдөр батлуулсан. МАЭ-ийн дэргэдэх Архитектур, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2024.11.29, "20 минутын хот" ҮХ-ны хурлаар 2024.12.18, тус яамны дэргэдэх ШУТТЗХ-аар 2024.12.20, ХБОСС-ын зөвлөлийн хурлаар 2024.12.23-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн. Мөн уг зураг төслийн баримт бичигт экспертизийн нэгдсэн дүгнэлт гаргуулахаар ХББОС-ын сайдын 2024.12.02-ны өдрийн 115 дугаар тушаалаар орон тооны бус экспертүүдийн ажлыг хэсгийг байгуулан ажиллаж байна.</p>	90
3	<p>Арга хэмжээ 2.5.6 Хот суурины үерийн далан суваг, борооны болон</p>	<p>Сэлэнгийн Сант сумын Ивэн голын боомтын үерийн далангийн барилга байгууламжийн</p>	<p>- "Ус зайлуулах суваг, шугам /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, Нарны хороолол-Дунд гол /XII.1.12/"- нь 2022 оноос хэрэгжиж байгаа, трассын давхцалтай уг ажлыг Нийслэлийн Хөрөнгө</p>	100

	хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	угсралтын ажлыг 100 хувь гүйцэтгэсэн байна. Шинэ Зуунмод хотын үерийн болон ус зайлуулах 2.4 км далан, суваг ашиглалтад оруулсан байна. Баянгол дүүргийн 3 дугаар хорооны ус зайлуулах 0.4км сувгийн ажлыг хийж дуусгасан байна.	оруулалтын газартай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байна. /50 хувь/ - Үерийн хамгаалалтын барилга байгууламж /Сэлэнгэ, Сант сум, Ивэн голын боомт/- “Эм Даблью Ти” ХХК-ийн Үерийн боомтын ажлыг 11 дүгээр сарын 15-ны өдрийн Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. - Шинэ Зуунмод хотод тус яамтай 2022/573 дугаартай гэрээ байгуулан хэрэгжсэн “Үерийн хамгаалалтын суваг-4 /4.9 км/”-ийн ажлыг гүйцэтгэсэн “Хангилцаг” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ашиглалтад оруулсан.	
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.				
Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ:				
4	Арга хэмжээ 3.2.1 Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно.	Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг өссөн дүнгээр 34476 иргэнд олгосон байна.	Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2024.12.01-ний өдрийн байдлаар 1,287.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 10,983 зээлдэгчид олгосон. 2021 оноос хойш 2024.12.01-ний өдрийн байдлаар нийт 35,147 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан байна. Батлан даалт гаргадаг болсон 2023 оноос хойш хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2024.12.01-ний өдрийг хүртэл нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батланд даалт хийсэн. Батлан даалтыг хамгийн их 196 Орхон, 132 Дорнод, 110 Баянхонгор, 76 Сүхбаатар, 71 Өвөрхангай, 69 Говь-Алтай, 63 Сэлэнгэ, 61 Дархан-Уул аймгуудад тус тус гаргаад байна.	100
5	Арга хэмжээ 3.2.2 Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.	Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулсан байна. Үзэл баримтлалыг УИХ-р батлуулсан байна.	Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан. Орон сууцжуулалтын тухай хуулийн үзэл баримтлал Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайд, Хууль зүйн, дотоод хэргийн сайд нараар батлуудсан. Хуулийн төсөл, түүний хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үзэл баримтлал, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, дагах хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын 2024.5.08-ны өдрийн хуралдаанаар дэмжигдэж, Улсын Их Хуралд 2024.5.16-ны өдөр өргөн барьж Эдийн засгийн байнгын хороогоор 2024.5.28-ны өдөр хэлэлцэн дэмжигдсэн.	100

			<p>Хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Улсын Их Хурлын 2024.5.30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдэж анхны хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангахаар Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараар ахлуулсан ажлын хэсэгт шилжүүлсэн. УИХ ээлжит сонгууль болж хуулийн төслийг ЗГ-т буцаасан. Засгийн газрын 2024.8.14-ний өдрийн хуралдаанаар “Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл”-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэнтэй холбоотойгоор тус яамны Сайдын 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2024.12.03-ны өдөр анхны хурал зохион байгуулсан.</p> <p>Хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авахаар 2024.11.25-ны өдрийн 2024/159 дугаартай хамтран ажиллах гэрээг “Легал инновешн хаав” ХХК-тай байгуулсан. Хуулийн зөвлөх үйлчилгээний компанитай 2024.12.05-ны өдөр уулзаж, холбогдох чиглэлийг өгч ажилласан.</p>	
6	<p>Арга хэмжээ 3.2.3 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгоно.</p>	<p>Төрийн түрээсийн орон сууцны тоог нэмэгдүүлэх хүрээнд "Ногоон нуур 1008 айлын орон сууц", "Солонго 1,2" орон сууцны төслийг эрчимжүүлсэн байна.</p>	<p>- Солонго-1, Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол төсөл"-ын барилга барих бэлтгэл ажил 18 блок барилгын төмөр бетон каркас цутгалтын ажил бүрэн дуусч, 5 блок 9 давхар, 12 блок 8 давхрын каркас цутгалтын ажил гүйцэтгэж, 2 дугаар ээлжийн 31 блок барилгаас энэ жил 16 блок барилгын суурийн ул бетон хийж үүнээс 11 барилгын суурийн бетон цутгалт, нэгдсэн гражийн цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Барилгын ажил төслийн хэмжээнд 35 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.</p> <p>- Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн орон сууцны барилга, сургууль, цэцэрлэгийн гадна хэрэгцээний цэвэр усны шугамын ажил 95 хувь, 1-8-р блокуудын төмөр бетон хийцийн ажил бүрэн дуусаж барилгын цонхны рам /шилтэй/ суурилуулалтын ажил 90.0 хувь хийгдэж байна. 2024 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 143,985,253.6 юань буюу 2022 онд 40.3 тэрбум төгрөг, 2023 онд 8.2 тэрбум төгрөг, 2024 онд 32.3 тэрбум төгрөг, нийт 67.9 төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд байна Төслийн нийт хэрэгжилт 2024.12.06-ны өдрийн байдлаар 75 хувийн гүйцэтгэлтэй байна</p>	100
7	<p>Арга хэмжээ 3.2.4 Барилгын</p>	<p>Дэмжин ажилласан БМҮ-н тоо -3, Засгийн</p>	<p>Шохойн үйлдвэрлэл дэмжиж: 1. Макс группын “Цэн газар” ХХК-ийн Говь-</p>	100

	цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	газрын тогтоол-1 Хамтын ажиллагааны гэрээ -1	Алтай аймгийн Тайшир суманд байгуулах цемент, шохойн үйлдвэрийн төслийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх асуудлыг Засгийн газрын 2024.01.25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж Засгийн газрын 37 дугаар тогтоолоор албажуулж, 3 талт гэрээний төслийг боловсруулан Сангийн сайдад 2024.02.08-ны өдрийн 1/457 тоот албан бичгээр хүргүүлэн санал авч, гэрээг албажуулан 2024.03.25-ны өдрийн 03/912 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
Зорилт 3.6. Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:				
8	Арга хэмжээ 3.6.1 Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-р хэлэлцүүлсэн байна. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-р батлуулсан байна.	- Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг ХББОСС-ын 2024 оны 79 дүгээр тушаалаар байгуулан шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсруулах, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан "20 минутын хот" стандартыг нэвтрүүлэх, хот төлөвлөлт, засаглалын шинэчлэлийг хийж, хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулах чиглэлээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг "Хууль зүйн бичигт хүрээлэн" НҮҮТББ-тай 2024.12.02-ны өдрийн 2024/192 тоот гэрээг гэрээ байгуулан ажиллаж байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2024.12.12-ны өдөр зохион байгуулсан Хот байгуулалтын форуммаар олон нийтэд хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгуулаад байна. 50 хувь/ - Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон бусад хууль тогтоолын төслийг Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024.05.01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын 2024.06.05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн, батлагдсан. /100 хувь/	90
9	Арга хэмжээ 3.6.6 Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой	Шинэ Хархорум хотын суурь судалгаа, ТЭЗҮ боловсруулсан байна. ХАНСХЕТ төслийг эцэслэн боловсруулж,	"Шинэ Хархорум" хотыг байгуулах 189363 га газрыг ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор тогтоож тусгай хэрэгцээнд авсан. Хотыг байгуулах ажлын хүрээнд холбогдох нийт 16 ажлын даалгавар батлагдаж хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	100

	<p>тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.</p>	<p>ШУТЗЗ-р хэлэлцүүлсэн байна.</p>	<p>боловсруулахад шаардлагатай суурь судалгаа болох хүн амын унд ахуйн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгаа /90 хувьтай/, байр зүйн зураг хийх, ортофото зураг үүсгэх / 20 хувьтай/, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /60 хувьтай/, инженерийн дэд бүтцийн эх үүсвэр тодорхойлох ТЭЗҮ /40 хувьтай/, археологийн хайгуул, судалгаа /40 хувьтай/ ажлууд хийгдэж байна.</p> <p>“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ боловсруулсан “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл”-ийг ШХХББ-ын Үндэсний хорооны 2023.10.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>- ХАНСХЕТ-ийн боловсруулах ажлын хүрээнд 1:2500000-ны масштаб бүхий 32 ширхэг альбом зураглалыг хийн эцэслэн боловсруулж байна. Түүнчлэн ХАНСХЕТ-ийн хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлтэй уялдуулахаар 2024.04.22-ны 02/1381 тоот албан бичгийг ЭЗХЯ-нд хүргүүлсний дагуу “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан.</p>	
<p>Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.</p>				
<p>Зорилт 4.2 Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:</p>				
<p>10</p>	<p>Арга хэмжээ 4.2.7 Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.</p>	<p>Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ-30 км, бохир усны шугам -40 км, дулааны шугам сүлжээ-15 км, цахилгааны шугам-10км</p>	<p>Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын "Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл" ажлын хүрээнд 1.5 км урт шугам сүлжээний гүйцэтгэж, 2024.10.10-ны өдөр ГАА-КД-08/2024, Баян-Өлгий аймгийн Өлгий суманд "Гэр хорооллын усан хангамжийн шугам сүлжээ төслийн хүрээнд 1380 м ус хангамжийн шугам сүлжээг гүйцэтгэж, 2024.10.03 өдрийн ББКД-83 05/24 дугаар бүхий комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг "Залуус 2" хорооллын гадна ус хангамжийн Ф200-Ф250мм-ын голчтой 3,35 км, Ф200-Ф250 мм-ийн 2,115 км шугам хоолойн ажлыг 2024.10.30-нд улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан. "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд 2024 онд 9.2 км ус хангамжийн шугам сүлжээний угсралтыг гүйцэтгэсэн. "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-</p>	<p>90</p>

			ний гүйцэтгэгч "Эс Энд Трейд" ХХК ус хангамжийн 2 дамжуулах Ф280х25.4 мм-ийн голчтой 3,756 км шугам, Эдийн засгийн чөлөөт бүсээс 1-15 худаг хүртлэх 2,69 км шугам, гол шугамын 1-р хэсгийн 4,83 км шугамын ажлыг гүйцэтгэж, 2024.12.06-нд улсын комисст хүлээлгэн өгсөн.	
Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.				
Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:				
11	<p>Арга хэмжээ 8.1.5 Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.</p>	<p>"Цагааннуур" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. Замын-Үүд Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүстэй уялдуулан төлөвлөх ажлын ЭЗХЯ-тай хамтран зохион байгуулна. "Цагаандэл-Уул" хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байна. Замын-Үүд боомтод барилгын материалын импортын хангамж төв байгуулах төслийн санал боловсруулж, ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>1.Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ШУТТЗ-ийн хурлаар 2023.12.08-ны өдөр, ХББОС-ын Сайдын зөвлөлийн 2024.11.13-ны өдөр тус тус хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд 2024.05.15-ны 0649/2024 дугаартай экспертизийн дүгнэлт гарсан. Уг зураг төслийн баримт бичгийг Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулахаар Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, 2024.11.05-ны өдрийн 01/1198 дугаартай албан бичгээр тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал аван, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. /70/</p> <p>2. Хоёр улсын Засгийн газрын хооронд байгуулсан "Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай" хэлэлцээрийн ажлын хүрээнд Монголын талаас ЭЗХЯ-ны ХОБГ-ын дарга Б.Анараар ахлуулсан баг, БНХАУ-ын талаас ӨМӨЗО-ны Худалдааны танхимын орлогч дарга Гоу Жөүминаар ахлуулсан ажлын хэсэг хамтран 2024.04.08-10-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүдийн чөлөөт бүс, БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүсэд ажилласан. "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөлд өгөх санал боловсруулж тус яамны 2024 оны 03/1250 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд ерөнхий төлөвлөгөө боловсруулах үнийн тооцооллын хамт хүргүүлсэн. /90/</p> <p>3."Цагаандэл-Уул" боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг тус яамны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар 2024.09.25-ны өдөр хэлэлцүүлж, зөвлөлөөс өгөгдсөн зөвлөмжийн дагуу Инженерийн байгууламж, шугам сүлжээний инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. /70/</p> <p>4. Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтуудад "Барилгын материалын импортын хангамж байгуулах" тухай ЭЗХЯ</p>	70

			дээр танилцуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын 3.6.23-т "Замын-Үүд хотын эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логикийн төвийг байгуулна." гэж тусгуулсан. Уг асуудлыг "Боомтын сэргэлтийн үндэсний хороо"-ны хурлаар хэлэлцүүлэхээр тус хороонд 2024.09.04-ний өдрийн 03/426 тоот албан бичгээр хүргүүлсэн. /90/	
12	<p>Арга хэмжээ 8.1.8 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр "Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.</p>	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг УИХ-р батлуулсан байна. Бүсчилсэн хөгжлийн салбарын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг харилцан уялдуулах зорилгоор 2024.04.22-ны 02/1381 тоот албан бичгээр холбогдох саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсний дагуу "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан. "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Зээлийн ерөнхий хэлэлцээр 2023 оны 07 дугаар сард УИХ-аар соёрхон батлагдсан ба 1-р үе шатны төслийн зээлийн тусгайлсан хэлэлцээрүүд МУЗГ болон АХБ хооронд 2024.01.11-ны өдөр байгуулагдан төсөл хэрэгжиж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлэх нэгж ЭЗХЯ-ны харьяа 2024 оны 6 сард бүрэн байгуулагдаж бүрдсэн бөгөөд үндсэн хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна. Уг хөтөлбөрийн 1-р үе шатны төсөл Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад хэрэгжих бөгөөд одоогоор төслийн хүрээнд "Төслийн хэрэгжилт болон менежмент, бодлогын зөвлөх үйлчилгээ"-ний ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, олон улсын нээлттэй тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулж байна. Барилгын ажлыг 2026 оноос эхлэн үе шаттайгаар эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100
13	<p>Арга хэмжээ 8.1.10 Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	7 сумын төвд инженерийн шугам сүлжээ шинээр барьж ашиглалтад оруулна.	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлуулсан. 1. Өвөрхангай, Хужирт сумын Дх27-Дх29, Дх4-Дх11, Дх18-Дх22 хүртэл трассын дагуу сувгийн ухлага хийгдэж, лотки болон шугамын угсралтыг гүйцэтгэн сувгийг таглаж булах ажил дуусгасан. Мөн нийт 23 худагны цутгалтын ажил хийгдэж дуусав. Бух18-20 худгийн ухлага болон шугам угсралт дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын комисс ажиллаж хүлээн авсан.100 хувь 2. Төв, Борнуур сумын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил дуусч,	90

			<p>улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. 100 хувь</p> <p>3. Төв аймгийн Дэлгэрхаан сумын инженерийн шугам сүлжээний ажлаас гадна ариутгах татуурга, гадна цахилгаан хангамжийн шугамын ажил дуусч улсын комисс ажиллаж хүлээн авсан. 100%.</p> <p>4. Төв аймгийн Сэргэлэн сумын инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэн улсын комисс ажиллаж хүлээн авсан. 100 хувь</p> <p>5.Төв аймгийн Эрдэнэ сумын инженерийн шугам сүлжээний 2024 оны ажлыг гүйцэтгэн инженерийн шугам сүлжээний ажлыг улсын комисс ажилласан байна. 100 хувь</p> <p>6. Төв аймгийн Баянчандмань сумын цэвэр усны эх үүсвэрийн 1150 м шугам хоолойн угсралтын ажил дууссан. Цэвэр усны 2 худгийн ажлыг гүйцэтгэсэн. 2 ширхэг усан сангийн ажил 90%-тай, нийт гүйцэтгэл 90% байна.</p> <p>7. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын төвийн гадна ариутгах татуургын PVC-U Ф160-200мм-ийн 2152 метр, "Аварга тосон" рашаан сувиллын газрын гадна ариутгах татуургын PVC-U Ф160-Ф200мм 3030 метр 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын 3,757 метр шугам, 100кВА-ын дэд өртөөний ажил, "Аварга тосон" рашаан сувиллын газрын 50м3/хон хүчин чадалтай бохир усны цооногийн ажлыг гүйцэтгэж дууссан. Сумын төвийн 100м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж гүйцэтгэн улсын комисс ажилласан. 100 хувь</p>	
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.				
Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.				
14	<p>Арга хэмжээ 9.2.3 Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.</p>	<p>Ногоон барилгын тогтолцоо бүрдүүлэх судалгааг боловсруулсан байна.</p>	<p>"Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал" /БД 25-102-24/ барилгын дүрэм Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 108 дугаар тушаалаар баталсан.</p>	100
Зорилт 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:				
15	<p>Арга хэмжээ 9.3.3 Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.</p>	<p>Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ-5.6 км, цахилгааны дэд өртөө-1 ком</p>	<p>"Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд ус хангамжийн 9,2 км шугам сүлжээг суурилуулж, 4662 ш ухаалаг тоолуур суурилуулах ажлыг гүйцэтгэсэн. "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн цахилгаан хангамжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ 2х630кВа-ын дэд өртөөний барилга 2-ыг барьж байгуулсан.</p>	100

Зорилт 9.4. Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ:				
16	Арга хэмжээ 9.4.1 Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно.	Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-р батлуулсан байна.	Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон бусад хууль тогтоолын төслийг Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024.05.01-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан бөгөөд УИХ-ын 2024.06.05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн, батлагдсан.	100
17	Арга хэмжээ 9.4.3 Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүнийг дагалдан гарах Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг улсын зэрэглэлтэй болгох тухай тогтоолын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран УИХ-д өргөн барьж, батлуулсан байна.	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 2024.06.05-ны өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан “Хот байгуулах тухай” УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгон тогтоосон.	100
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ:				
18	Арга хэмжээ 9.5.1 Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	Төв аймгийн Номтын аманд төр захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулна. Эдийн засгийн чөлөөт бүсийн ХЕТ-ийг батлуулна. Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлэх хүрээнд “Шинэ Зуунмод” хотын эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д	1. “Төрийн захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолборын зураг төслийн техникийн тодорхойлолт боловсруулах ажлыг даалгавар”-ыг тус яам нь ЭЗХЯ-тай хамтран баталсны дагуу зөвлөх үйлчилгээний гэрээг зөвлөх багтай 2024.09.24-ний өдөр байгуулсан. Зөвлөх багаас боловсруулсан техникийн тодорхойлолтын төсөлтэй танилцаж, холбогдох саналыг 2024.10.28-ны өдөр ЭЗХЯ-нд хүргүүлэн ажлын хэсгийн 2024.10.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. /90/ 2. “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-аас боловсруулсан “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2024 оны 1731/2024 дугаар экспертизийн нэгдсэн дүгнэлт гарсан. Уг ерөнхий төлөвлөгөөг ЗГ-ын хуралдаанаар	100

		<p>батлуулсан байна. Бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг техник туслалцаа, зээлийн хэлэлцээрт хамруулах ажлыг зохион байгуулна. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн /одоо хэрэгжиж байгаа/ инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.</p>	<p>хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан. /70/ 3. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар 2024.06.05-ны өдөр батлагдсан. Хууль батлагдсантай холбогдуулан УИХ-ын 2024 оны 76 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотыг нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байхаар шийдвэрлэж, хилийн цэсийг тогтоосон. /100/ 4. Зөвлөх “Гоби Травэл” ХХК-ийн боловсруулсан “Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүсийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажлыг Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2024.11.22, ШУТТЗХ-аар 2024.12.20-ны өдөр тус тус хэлэлцүүлсэн. /100/ 5. Шинэ Зуунмод” хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2х10000кВА чадалтай “Хөндий” дэд станц, 110/35/10кВ-ын “Зуунмод” дэд станцын өргөтгөл /Төв/, Дэд станцын барилга тоноглолтой, 35кВ ил хуваарилах байгууламж тоноглолтой, нийт 105 ширхэг анкер цахилгаан дамжуулах агаарын шугам 15,7 км комисс ажиллахад бэлэн болсон, ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ажлыг 2024.12.06-ны өдөр, “Үерийн хамгаалалтын суваг - 4 /4.9 км/” 2024.11.04-ний ББКД-79/2024 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад орсон.</p>	
19	<p>Арга хэмжээ 9.5.2 Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.</p>	<p>Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хүрээнд Төв аймгийн Сэргэлэн суманд нисэх онгоцны буудлыг түшиглэн бий болгох Логистикийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>“Олон улсын нисэх онгоцны “Чингис Хаан” буудлыг түшиглэн бий болох Богд Хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн судалгаа, эх үүсвэр тодорхойлох” ажилд 2022.12.15-ны өдрийн 2701/2022 тоот магадлалын нэгдсэн дүгнэлт гарч, Төв аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн, ИТХ-ын 2023 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан.</p>	100
20	<p>Арга хэмжээ 9.5.4 Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг</p>	<p>Хөтөлийн “Цемент шохой” ТӨХК-ийг түшиглэн барилгын материалын ҮТП байгуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.</p>	<p>1. “Бүтээн байгуулалтын зарим төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Налайхын болон Хөтөлийн “Барилгын материалын парк”-ын бүтэц, төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамыг тогтоох заалт оруулах саналыг Аж үйлдвэр, эрдэс</p>	100

	байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.		<p>баялгийн сайдад 2024.10.01-ний өдрийн 01/703 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2. БХБ-ын сайдын НЗД-тай байгуулах гэрээнд Налайхын БМҮТП-ын чиглэлээр хамтран ажиллах талаар тусгасан. Нийслэлийн төсөвт энэ онд 16.2 тэрбум төгрөг тусгаж, 2*16 мегаватт цахилгаан хангамжийг байгуулснаар тус паркад орж ажиллахаар 12 аж ахуйн нэгж Паркын захиргаатай гэрээ байгуулж, барилгын ажлаа гүйцэтгэж байна.</p> <p>3. “МАК” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн суманд барилгын материалын 8 үйлдвэр байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаатай холбогдуулан аж үйлдвэрийн парк байгуулах талаар мэргэжил, аргазүйн зөвлөгөө үзүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хуванцар поддоны үйлдвэр • Хуванцар профилын үйлдвэр • Хуванцар уут шуудайн үйлдвэр • Хуванцар хоолойн үйлдвэр • Шил ганжуулах үйлдвэр, • Бүрэн автомат будгийн цех, • MDF хаалганы үйлдвэр <p>• Зуурмагийн үйлдвэр</p>	
21	<p>Арга хэмжээ 9.5.6 цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.</p>	<p>Шинэ Зуунмод хотын хоёрдугаар ээлжийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгавар батлагдсан байна. Бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг техник туслалцаа, зээлийн хэлэлцээрт хамруулах ажлыг зохион байгуулна. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, цахилгаан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн байна. Богдхан Уулын Номт амны ерөнхий төлөвлөгөө, "Шинэ Зуунмод" хотын төв, засаг захиргааны бүсийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.</p>	<p>1. АХБ-ны “Хөшигийн хөндийн дасан зохицох чадавхтай, ногоон, шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажлыг 2025 оны зээлийн ерөнхий хэлэлцээрт тусгуулах тухай саналыг тус яамны 2024 оны 01/892 тоот албан бичгээр ЭЗХЯ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. Төслийн зөвлөхөөр Японы “АЛМЕК Корпораци” компаниар ахлуулсан консорциум баг ажиллаж байгаа ба ТЭЗҮ-г холбогдох орон тооны бус мэргэжлийн зөвлөлүүдийн 2024.10.03-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн төслийн ТЭЗҮ-д Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэн БОУАӨЯ-ны 2024.10.03-ны өдрийн 2023/ОА-43 дугаар ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан. Уг техник туслалцааны хүрээнд төслийн зөвлөх багаас 8 тайлангуудыг боловсруулан тус яаманд ирүүлээд байна.</p> <p>2. ЖАЙКА-ын техник туслалцааны “Шинэ Зуунмод хот болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төсөл”-ийг 2023.12.08-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох санал боловсруулж, хуулийг дагалдаж гарах дүрэм, журмын төсөл боловсруулан хотын институцийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Уг төслийн Хамтарсан зохицуулах хорооны хурлыг 2024.12.13-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>3. “Төрийн захиргааны байгууллагуудын</p>	90

			нэгдсэн цогцолборын зураг төслийн техникийн тодорхойлолт боловсруулах ажлыг даалгавар"-ыг тус яам нь ЭЗХЯ-тай хамтран баталсны дагуу зөвлөх үйлчилгээний гэрээг зөвлөх багтай 2024.09.24 өдөр байгуулсан. Зөвлөх багаас боловсруулсан техникийн тодорхойлолтын төсөлтэй танилцаж, холбогдох саналыг 2024.10.28-ны өдөр ЭЗХЯ-нд хүргүүлэн ажлын хэсгийн 2024.10.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.	
Үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилт				95.71

Дараах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

“Шинэ Хархорум” хотыг байгуулах 189363 га газрыг ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор тогтоож тусгай хэрэгцээнд авсан. Хотыг байгуулах ажлын хүрээнд холбогдох нийт 16 ажлын даалгавар батлагдаж хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай суурь судалгаа болох хүн амын унд ахуйн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгаа /90 хувьтай/, байр зүйн зураг хийх, ортофото зураг үүсгэх / 20 хувьтай/, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /60 хувьтай/, инженерийн дэд бүтцийн эх үүсвэр тодорхойлох ТЭЗҮ /40 хувьтай/, археологийн хайгуул, судалгаа /40 хувьтай/ ажлууд хийгдэж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг харилцан уялдуулах зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 22-ны 02/1381 тоот албан бичгээр холбогдох саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсний дагуу “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан.

Ногоон барилгын тогтолцоог бүрдүүлэхэд “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал” /БД 25-102-24/ барилгын дүрэм Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан.

Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн, батлагдсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан “Хот байгуулах тухай” УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгон тогтоосон.

Эрчимжүүлэх шаардлагатай, 70 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 8.1.5 Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.

2024 онд хүрэх түвшин:

"Цагааннуур" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна.

Замын-Үүд Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн яамтай



хамтран БНХАУ-ын Эрээн хотын чөлөөт бүстэй уялдуулан төлөвлөх ажлын ЭЗХЯ-тай хамтран зохион байгуулна.

"Цагаандэл-Уул" хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байна.

Замын-Үүд боомтод барилгын материалын импортын хангамж төв байгуулах төслийн санал боловсруулж, ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээний 9 зорилт, 21 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **95.71** хувьтай, **"тодорхой үр дүнд хүрсэн"** гэж дүгнэв.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулинд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар "9.1.3. төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах" нэмэлт заалтыг тусгуулж батлуулсан. Үүний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А-255 дугаар тушаалаар "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-д "2.1.4 Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргасан тохиолдолд урьдчилгаа төлбөр 12 хувиас доошгүй (ЗҮХ 88 хувиас дээшгүй), бусад тохиолдолд урьдчилгаа төлбөр 30 хувиас доошгүй (ЗҮХ 70 хувиас дээшгүй)" гэсэн нэмэлт заалт орсоноор ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах асуудлыг бүрэн шийдвэрлүүлсэн байна.

Тус зохицуулалтыг шийдвэрлүүлснээс хойш хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батлан даалт хийсэн. Орхон аймагт 196, Дорнод 132, Баянхонгор 110, Сүхбаатар 76, Өвөрхангай 71, Говь-Алтай 69, Сэлэнгэ 63, Дархан-Уул аймагт 61 иргэнд тус тус батлан даалт гаргасан байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх нийт 1,145,3 тэрбум төгрөгийн 405,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 179 төсөл арга хэмжээнээс 2024 оны эцсийн жилийн байдлаар нийт 70 төсөл, арга хэмжээ улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Бүх газар хэлтэст зөвлөмж болгох нь:

1. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчлэх, агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан, 70, 90 хувьтай бүрэн хэрэгжүүлж дуусгах 8 арга хэмжээг 2025 оны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжих хугацаа 2025 онд дуусч байгаа тул тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилго, зорилт, заалт бүрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөж байна.

Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

4. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах ажлыг эрчимжүүлж ажиллах;

Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

5. “Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээг яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

6. Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд аймаг нийслэлийн нэгдсэн судалгаа гаргах, жил бүрийн хэрэгжсэн ажилтай уялдуулан мэдээллийн сангийн баяжуулалт хийх, төлөвлөлтийг сайжруулахад анхаарч ажиллах;

Тайлбар:

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилт болон 1-5-р хавсралтуудыг хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР